**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Палеонтологийн хүрээлэнгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СНАГ-2025/256/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: П.Чанцалдулам<br>Утас: 51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn<br>Ахлах аудитор:Д.Мөнхжин<br>Утас:261628 Цахим хаяг: munkhjind@audit.gov.mn<br>Аудитор: О.Наранбат<br>Утас:261628 Цахим хаяг: naranbato@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.24 № 07/642

танай ____________-ны №____________-т

ПАЛЕОНТОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ З.БАДАМХАТАН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Палеонтологийн хүрээлэнгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дараах зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Төсвийн төсөлд төлөвлөөгүй, төсвийн хөрөнгө оруулалтыг төсөвлөх төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагыг хангаагүй барилгын зураг төсвийн ажилд нийт 27,261.8 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан;

- ШУА-ийн ерөнхийлөгчийн 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/189 дүгээр тушаалаар Палеонтологийн хүрээлэнгийн захирлын эрүүл мэндийн нөхцөл байдал, ар гэрийн хүсэлтийг харгалзан хүрээлэнгийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 1 дүгээр гарын үсэг зурах эрхийг тус хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн даргад шилжүүлсэн боловч хүрээлэнгийн захирлын ажиллаагүй 2024 оны 11, 12-р сард 9,300.9 мянган төгрөгийн цалин бодож олгосон;

- ШУА-ийн Палеонтологийн хүрээлэнгийн захирлын 2024 оны "Ажилд түр авах тухай" Б/47 дугаар тушаалаар хүрээлэнгийн албан хаагч ээлжийн амралтаа эдэлж байх хугацаанд нэр бүхий иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулж, түр ажиллуулсан.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, $29^1$ дүгээр зүйлийн $29^1$.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 13 дугаар зүйлийн 13.7, Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.1.1 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын Нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.



1525070065

**Асуудлыг онцолсон хэсэг**

Палеонтологийн хүрээлэн тайлант онд сан хөмрөгийн барилгын урсгал засварын ажилд 65,000.0 мянган төгрөг, төв байрны нэг давхарт "Эртний организмын сор олдворууд" шилэн хорго бүхий үзмэрийн танхим тохижуулахад 33,668.4 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар бүлгийн 27 дугаар зүйлийн 27.8-д "...палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна" гэж заасны дагуу аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, гэрээний 10.0 хувь болох 66,061.4 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд авч зарцуулсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Палеонтологийн хүрээлэнг 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамруулсан бол тайлант оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Төрийн аудитын байгууллага аудит гүйцэтгэж, дүгнэлт гаргалаа.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АТА9693 9006109
9023030583

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 172,934,832.14 | 232,876,683.29 |
| **33** | **АВЛАГА** | - | 29,294,235.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 29,294,235.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 2,409,210.10 | 21,584,316.01 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | - | 21,261,076.92 |
| 34700 | Бусад урьдчилгаа | 2,409,210.10 | 323,239.09 |
| 34710 | Урьдчилгаа тооцоо | 2,409,210.10 | 323,239.09 |
| 34711 | Бараа материал бэлтгэх урьдчилгаа | 712,693.10 | 323,239.09 |
| 34714 | Томилолтын урьдчилгаа | 1,696,517.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 170,525,622.04 | 181,998,132.28 |
| 351 | Түүхий эд материал | 4,802,214.54 | 6,562,714.54 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 4,802,214.54 | 6,562,714.54 |
| 354 | Хангамжийн материал | 165,723,407.50 | 175,435,417.74 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 10,310,370.01 | 7,931,055.01 |
| 35420 | Аж ахуйн материал | 106,319,552.49 | 112,575,400.73 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,505,500.00 | 1,505,500.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,699,000.00 | 559,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,481,810.00 | 3,058,810.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 44,407,175.00 | 49,805,652.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,214,258,080.08** | **4,132,409,696.65** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **4,214,258,080.08** | **4,132,409,696.65** |
| 392 | Биет хөрөнгө | 3,961,404,612.59 | 3,887,552,479.20 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,485,707,447.26 | 1,485,707,447.26 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (143,789,905.85) | (178,888,471.85) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 134,310,984.00 | 126,502,800.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (57,121,790.00) | (61,927,800.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 795,100,671.53 | 856,071,814.01 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (405,852,174.87) | (545,393,739.34) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 100,541,807.36 | 134,210,240.36 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (32,246,397.54) | (47,557,385.10) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 2,065,195,000.00 | 2,084,495,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 19,003,371.28 | 37,103,371.28 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (3,752,465.63) | (7,078,862.47) |
| 39217 | Номын фонд | 4,308,065.05 | 4,308,065.05 |
| 393 | Биет бус хөрөнгө | 252,853,467.49 | 244,857,217.45 |
| 39301 | Програм хангамж | 19,754,500.00 | 19,754,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (3,748,812.51) | (11,745,062.55) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 236,847,780.00 | 236,847,780.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,387,192,912.22** | **4,365,286,379.94** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,387,192,912.22** | **4,365,286,379.94** |

| | | | |
|---|---|---|---|
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **4,387,192,912.22** | **4,365,286,379.94** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 3,669,354,717.94 | 3,669,354,717.94 |
| 51101 | Засгийн газрын оруулсан капитал засгийн газрын сан | 3,669,354,717.94 | 3,669,354,717.94 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 691,629,900.99 | 669,723,368.71 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 743,675,487.53 | 691,629,900.99 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (52,045,586.54) | (21,906,532.28) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 26,208,293.29 | 26,208,293.29 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **4,387,192,912.22** | **4,365,286,379.94** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,606,364,865.39** | **2,008,843,404.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **27,848,737.00** | **58,374.00** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 27,848,737.00 | 58,374.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 174,527.00 | 58,374.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 174,527.00 | 58,374.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 27,674,210.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,578,516,128.39** | **2,008,785,030.00** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,412,606,600.00 | 1,887,281,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,412,606,600.00 | 1,887,281,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 165,909,528.39 | 121,503,330.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 103,702,466.99 | 57,138,400.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 62,207,061.40 | 64,364,930.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **1,658,410,451.93** | **2,030,749,936.28** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,658,410,451.93** | **2,030,749,936.28** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,631,244,474.42 | 1,954,177,270.64 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 855,844,925.40 | 1,193,948,383.57 |
| 210101 | Үндсэн цалин | 606,508,424.13 | 895,507,362.54 |
| 210102 | Нэмэгдэл | 147,751,366.60 | 179,698,826.03 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 76,487,000.00 | 76,917,000.00 |
| 210104 | Урамшуулал | 20,313,587.00 | 41,825,195.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 4,784,547.67 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 106,827,829.32 | 134,161,749.58 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 76,455,001.98 | 91,943,467.72 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,928,535.25 | 11,944,150.95 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,856,828.15 | 6,153,546.09 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,326,133.04 | 4,757,268.81 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,261,330.90 | 19,363,316.01 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 17,290,031.39 | 20,910,001.21 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,905,845.88 | 8,695,841.84 |
| 210302 | Түлш, халаалт | 5,384,615.27 | 5,742,033.16 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,999,570.24 | 6,472,126.21 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 31,434,344.95 | 20,913,591.87 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,398,355.00 | 5,739,315.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 587,800.00 | 814,022.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 990,093.06 | 961,176.10 |

| | | | |
|---|---|---|---|
| 210404 | Ном, хэвлэл | 13,241,506.88 | 8,151,621.77 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,740,000.00 | 2,640,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,947,120.00 | 2,607,457.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 6,529,470.00 | - |
| 2105 | Нормативт зардал | 9,199,095.00 | 4,527,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,779,095.00 | 4,333,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 7,420,000.00 | 194,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,054,750.30 | 80,834,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,054,750.30 | 80,834,100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 69,240,473.00 | 47,108,471.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 26,068,714.00 | 10,174,665.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 43,171,759.00 | 36,933,806.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 250,163,664.78 | 207,826,333.90 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 239,816,330.78 | 204,937,946.90 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 136,920.00 | 106,920.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 318,495.00 | 206,148.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 8,333,600.00 | 1,017,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,536,319.00 | 1,536,319.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 283,189,360.28 | 243,947,639.51 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 85,268,933.00 | 21,066,923.08 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 197,920,427.28 | 222,880,716.43 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 27,165,977.51 | 76,572,665.64 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 2,400,000.00 | 35,718,217.78 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,400,000.00 | 750,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 34,968,217.78 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 24,765,977.51 | 40,854,447.86 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 23,616,380.97 | 24,074,419.86 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 1,149,596.54 | 16,780,028.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I-II)** | **(52,045,586.54)** | **(21,906,532.28)** |
| **6** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III+IV-V)** | **(52,045,586.54)** | **(21,906,532.28)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,604,192,759.96** | **2,010,481,547.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,604,192,759.96** | **2,010,481,547.00** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,412,606,600.00 | 1,887,281,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,412,606,600.00 | 1,887,281,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 191,586,159.96 | 123,199,847.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 102,818,500.00 | 57,138,400.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 88,767,659.96 | 66,061,447.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)** | **1,465,317,020.46** | **1,869,449,214.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,465,317,020.46** | **1,869,449,214.00** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,438,151,042.95 | 1,763,582,313.36 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 855,844,925.40 | 1,193,937,100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 608,705,203.13 | 895,546,078.97 |

| | | | |
|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | 146,410,682.83 | 179,664,826.03 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 76,484,075.27 | 76,901,000.00 |
| 210104 | Урамшуулал | 19,460,416.50 | 41,825,195.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 4,784,547.67 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 106,827,829.32 | 134,173,033.15 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 76,455,001.93 | 91,943,467.67 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,928,535.25 | 11,944,150.95 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,856,828.17 | 6,153,546.09 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,326,133.03 | 4,757,268.81 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,261,330.94 | 19,374,599.63 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 17,290,031.39 | 20,910,001.21 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,905,845.88 | 8,695,841.84 |
| 210302 | Түлш, халаалт | 5,384,615.27 | 5,742,033.16 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,999,570.24 | 6,472,126.21 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 26,283,963.06 | 16,313,276.10 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,028,000.00 | 3,245,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 990,093.06 | 961,176.10 |
| 210404 | Ном, хэвлэл | 14,775,150.00 | 4,890,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,740,000.00 | 2,640,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,750,720.00 | 4,577,100.00 |
| 2105 | Нормативт зардал | 8,639,505.00 | 8,075,500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 5,629,505.00 | 8,075,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,010,000.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,490,000.00 | 88,550,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,490,000.00 | 88,550,900.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 65,650,089.00 | 46,334,665.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 26,093,089.00 | 10,174,665.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 39,557,000.00 | 36,160,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 269,743,624.78 | 212,959,837.90 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 261,333,490.78 | 205,830,450.90 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 136,920.00 | 106,920.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 318,495.00 | 206,148.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 6,396,400.00 | 5,258,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,536,319.00 | 1,536,319.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 86,381,075.00 | 42,328,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 86,381,075.00 | 42,328,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 27,165,977.51 | 105,866,900.64 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 2,400,000.00 | 35,718,217.78 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,400,000.00 | 750,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 34,968,217.78 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 24,765,977.51 | 70,148,682.86 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 23,616,380.97 | 24,074,419.86 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 1,149,596.54 | 46,074,263.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I-II)** | **138,875,739.50** | **141,032,333.00** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)** | **-** | **-** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **138,875,739.50** | **141,032,333.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **138,875,739.50** | **141,032,333.00** |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | 138,875,739.50 | 141,032,333.00 |
| 2251 | Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн | 138,875,739.50 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 138,875,739.50 | 141,032,333.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV-V)** | **(138,875,739.50)** | **(141,032,333.00)** |
| 9 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **-** | **-** |
| 10 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **-** | **-** |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)** | **-** | **-** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III+VI+VII)** | **-** | **-** |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **-** |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **-** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *//төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 3,669,354,717.94 | - | 743,675,487.53 | 4,413,030,205.47 |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **3,669,354,717.94** | **-** | **743,675,487.53** | 4,413,030,205.47 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | 26,208,293.29 | - | 26,208,293.29 |
| 7 | Тайлант үеийн үр дүн | - | - | (52,045,586.54) | (52,045,586.54) |
| 9 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,669,354,717.94** | **26,208,293.29** | **691,629,900.99** | 4,387,192,912.22 |
| 11 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **3,669,354,717.94** | **26,208,293.29** | **691,629,900.99** | 4,387,192,912.22 |
| 16 | Тайлант үеийн үр дүн | - | - | (21,906,532.28) | (21,906,532.28) |
| 17 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,669,354,717.94** | **26,208,293.29** | **669,723,368.71** | 4,365,286,379.94 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,887,281,700.00** | **1,863,207,280.14** | **24,074,419.86** | **98.72** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,887,281,700.00** | **1,863,207,280.14** | **24,074,419.86** | **98.72** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,851,487,900.00** | **1,827,489,062.36** | **23,998,837.64** | **98.70** |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,193,937,100.00 | 1,193,937,100.00 | - | 100.00 |
| Үндсэн цалин | 728,469,000.00 | 895,546,078.97 | (167,077,078.97) | 122.94 |
| Нэмэгдэл | 394,506,100.00 | 179,664,826.03 | 214,841,273.97 | 45.54 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 70,962,000.00 | 76,901,000.00 | (5,939,000.00) | 108.37 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Урамшуулал | - | 41,825,195.00 | (41,825,195.00) | - |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 150,492,200.00 | 134,173,033.15 | 16,319,166.85 | 89.16 |
| Тэтгэврийн даатгал | 102,334,700.00 | 91,943,467.67 | 10,391,232.33 | 89.85 |
| Тэтгэмжийн даатгал | 12,039,400.00 | 11,944,150.95 | 95,249.05 | 99.21 |
| ҮОМШӨ-ний даатгал | 6,019,700.00 | 6,153,546.09 | (133,846.09) | 102.22 |
| Ажилгүйдлийн даатгал | 6,019,700.00 | 4,757,268.81 | 1,262,431.19 | 79.03 |
| Эрүүл мэндийн даатгал | 24,078,700.00 | 19,374,599.63 | 4,704,100.37 | 80.46 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 22,479,000.00 | 20,910,001.21 | 1,568,998.79 | 93.02 |
| Гэрэл, цахилгаан | 11,400,900.00 | 8,695,841.84 | 2,705,058.16 | 76.27 |
| Түлш, халаалт | 7,782,500.00 | 5,742,033.16 | 2,040,466.84 | 73.78 |
| Цэвэр, бохир ус | 3,295,600.00 | 6,472,126.21 | (3,176,526.21) | 196.39 |
| Хангамж, бараа материалын зардал | 8,083,300.00 | 8,079,476.10 | 3,823.90 | 99.95 |
| Бичиг хэрэг | 236,000.00 | 440,000.00 | (204,000.00) | 186.44 |
| Тээвэр, шатахуун | 714,800.00 | - | 714,800.00 | - |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 430,800.00 | 961,176.10 | (530,376.10) | 223.11 |
| Ном, хэвлэл | 2,973,300.00 | 1,467,000.00 | 1,506,300.00 | 49.34 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 529,300.00 | 2,510,000.00 | (1,980,700.00) | 474.21 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,199,100.00 | 2,701,300.00 | 497,800.00 | 84.44 |
| Нормативт зардал | 1,368,000.00 | - | 1,368,000.00 | - |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,368,000.00 | - | 1,368,000.00 | - |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 137,184,700.00 | 137,143,900.00 | 40,800.00 | 99.97 |
| Багаж, техник, хэрэгсэл | 68,514,700.00 | 68,513,900.00 | 800.00 | 100.00 |
| Урсгал засвар | 68,670,000.00 | 68,630,000.00 | 40,000.00 | 99.94 |
| Томилолт, зочны зардал | 21,154,700.00 | 21,010,000.00 | 144,700.00 | 99.32 |
| Дотоод албан томилолт | 21,154,700.00 | 21,010,000.00 | 144,700.00 | 99.32 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 274,398,200.00 | 269,907,551.90 | 4,490,648.10 | 98.36 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 272,943,400.00 | 268,964,883.90 | 3,978,516.10 | 98.54 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 404,100.00 | - | 404,100.00 | - |
| Даатгалын үйлчилгээ | 144,100.00 | 106,920.00 | 37,180.00 | 74.20 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 262,600.00 | 206,148.00 | 56,452.00 | 78.50 |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 36,400.00 | 22,000.00 | 14,400.00 | 60.44 |
| Газрын төлбөр | 607,600.00 | 607,600.00 | - | 100.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 42,390,700.00 | 42,328,000.00 | 62,700.00 | 99.85 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 42,390,700.00 | 42,328,000.00 | 62,700.00 | 99.85 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 35,793,800.00 | 35,718,217.78 | 75,582.22 | 99.79 |
| Бусад урсгал шилжүүлэг | 35,793,800.00 | 35,718,217.78 | 75,582.22 | 99.79 |
| Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 825,500.00 | 750,000.00 | 75,500.00 | 90.85 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 34,968,300.00 | 34,968,217.78 | 82.22 | 100.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,887,281,700.00 | 1,863,207,280.14 | 24,074,419.86 | 98.72 |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,887,281,700.00 | 1,863,207,280.14 | 24,074,419.86 | 98.72 |
| Улсын төсвөөс санхүүжих | 1,887,281,700.00 | 1,863,207,280.14 | 24,074,419.86 | 98.72 |
| **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 | - | 100.00 |
| Төсвийн байгууллага | 1 | 1 | - | 100.00 |
| **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 47 | 47 | - | 100.00 |
| Удирдах ажилтан | 8 | 8 | - | 100.00 |
| Гүйцэтгэх ажилтан | 39 | 39 | - | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)** | | **123,199,847.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **123,199,847.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **77,125,584.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **8,233,800.00** |
| 210401 | Бичиг хэрэг | | 2,805,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | 3,423,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 130,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 1,875,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | | **8,075,500.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 8,075,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **19,920,900.00** |
| 210604 | Урсгал засвар | | 19,920,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | **25,324,665.00** |
| 210701 | Гадаад албан томилолт | | 10,174,665.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 15,150,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **15,570,719.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 9,384,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 5,258,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | | 928,719.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **46,074,263.00** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **46,074,263.00** |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 46,074,263.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)** | | **123,199,847.00** |
| **1311** | **Тусламж, санхүүжилтийн орлого** | | **123,199,847.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 57,138,400.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 66,061,447.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | **-** |
| 11000 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | - |
| 12000 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | - |

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

**3.1** Аудитаар нийт 143,029.5 мянган төгрөгийн 5 алдаа илэрснээс аудитын явцад залрууллаа.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага зардлын ангиллаас гарсан албан хаагчдын сургалтын төлбөрийн тайлант онд ногдохгүй зардлыг урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй шууд зардлаар бүртгэсэн байна. | 1 | 21,261.1 | | | 1 | 21,261.1 | 1 | 21,261.1 | | | | |
| Үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг шууд зардлаар бүртгэсэн байна. | 1 | 20,750.0 | | | 1 | 20,750.0 | 1 | 20,750.0 | | | | |
| ТӨБЗГ-ын 2024 оны 370 дугаар тогтоолоор Палеонтологийн хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2 тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлагын худалдаа зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг 1,750.0 мянган төгрөгөөр тогтоосон байна. Гэвч хүрээлэн тус хөрөнгүүдийг дахин үнэлгээний нэмэгдэл 2,350.0 мянган төгрөгөөр бүртгэж, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор хүлээн зөвшөөрсөн байна. | 1 | 2,350.0 | | | 1 | 2,350.0 | 1 | 2,350.0 | | | | |
| Төв байрны нэг давхарт ‘’Эртний организмын сор олдворууд‘’ шилэн хорго бүхий үзмэрийн танхим тохижуулсан 33,668.4 мянган төгрөгийг барилга байгууламжийн сайжруулалтаар хүлээн зөвшөөрч, капиталжуулсан байна. | 1 | 33,668.4 | | | 1 | 33,668.4 | 1 | 33,668.4 | | | | |
| Хөрөнгийн ирээдүйн үр өгөөжийг нэмэгдүүлээгүй, хэвээр хадгалан, нөхөн сэргээж байгаа засвар буюу хүрээлэнгийн сан хөмрөгийн барилгад хийсэн 65,000.0 мянган төгрөгийн шалны засварын ажлыг барилга байгууламжийн сайжруулалтаар хүлээн зөвшөөрч, капиталжуулсан байна. | 1 | 65,000.0 | | | 1 | 65,000.0 | 1 | 65,000.0 | | | | |
| **Дүн** | **5** | **143,029.5** | **-** | **-** | **5** | **143,029.5** | **5** | **143,029.5** | **-** | **-** | **-** | **-** |

**3.2** Аудитаар нийт 38,515.9 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс, 1,953.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 36,562.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| ШУА-ийн ерөнхийлөгчийн 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/189 дүгээр тушаалаар Палеонтологийн хүрээлэнгийн захирлын эрүүл мэндийн нөхцөл байдал, ар гэрийн хүсэлтийг харгалзан хүрээлэнгийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 1 дүгээр гарын үсэг зурах эрхийг тус хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн даргад шилжүүлсэн боловч хүрээлэнгийн захиралд цагийн бүртгэлгүй 2024 оны 11 болон 12-р сард 9,301.0 мянган төгрөгийн цалин бодож олгосон байна. | 1 | 9,301.0 | | | 1 | 9,301.0 | | | | | | |
| Төсвийн төсөлд төлөвлөөгүй, төсвийн хөрөнгө оруулалтыг төсөвлөх төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагыг хангаагүй барилгын зураг төсвийн ажилд нийт 27,261.8 мянган төгрөгийг зарцуулж, үр ашиггүй зардал гаргасан байна. | 1 | 27,261.8 | | | 1 | 27,261.8 | | | | | | |
| Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 141,765.1 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 7,755.3 мянган төгрөгийн тавилга, аж ахуйн эд хогшил, 2,748.0 мянган төгрөгийн програм хангамж бүртгэлтэй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| ШУА-ийн Палеонтологийн хүрээлэнгийн захирлын 2024 оны "Ажилд түр авах тухай" Б/47 дугаар тушаалаар хүрээлэнгийн албан хаагч ээлжийн амралтаа эдэлж байх хугацаанд нэр бүхий иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулж, түр ажиллуулан нийт 1,953.1 мянган төгрөгийн цалин олгосон байна. | 1 | 1,953.1 | 1 | 1,953.1 | | | | | | | | |
| **Дүн** | **4** | **38,515.9** | **1** | **1,953.1** | **2** | **36,562.8** | **1** | - | - | - | - | - |

**3.3** АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 3 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Шилэн дансны цахим системд хуулийн хугацаанд ил тод мэдээлэхээс 29 зарлагын мэдээллийг хугацаа хоцроож, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 361,027.1 мянган төгрөгийн 6 орлогын гүйлгээ, 5,623.8 мянган төгрөгийн 1 зарлагын гүйлгээг тус тус байршуулаагүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| **Дүн** | **1** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **-** |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар бүлгийн 27 дугаар зүйлийн 8-д заасны дагуу Палеонтологийн хүрээлэн нь урьдчилан хайгуул, судалгаа хийж, дүгнэлт гаргах ажлын хүрээнд аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж нэмэлт орлого олж байна. Нэмэлт орлоготой холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:<br>- Нэмэлт санхүүжилтийн данс руу гэрээний төлбөрийн зөвхөн 10 хувьтай тэнцэх орлогыг төвлөрүүлэх, судалгаа хийх зардлын төсвийг боловсруулах нарийвчилсан журам, зохицуулалт байхгүй;<br>- Хүрээлэнгийн албан хаагчид тус судалгааны ажлын хүрээнд томилолтоор ажиллах хугацааны цалинг давхар бодон олгосон;<br>- Жил бүр давтагдах шинжтэй орлогыг төсвийн төсөлд төлөвлөж, орлогын төлөвлөгөө батлуулаагүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| Цаг бүртгэлийн системгүй, ажилчдын цагийн бүртгэлд тавих дотоод хяналт сул байна. | 1 | - | | | | | 1 | - |
| **Дүн** | **2** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **2** | **-** |
| **Нийт дүн** | **3** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **3** | **-** |